



# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 8 (389)

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

- *Олон нийтийн радио, телевизийн тухай*
- *Төрийн өмчөөс олон нийтийн өмчид эд хөрөнгө шилжүүлэх тухай*
- *Олон нийтийн радио, телевизийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай*

Улсын Их Хурлын Тамгын газар  
Улаанбаатар хот  
2005 он



# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ  
Долоо хоног тутмын

Улаанбаатар хот

2005 оны хоёрдугаар сарын 28

№8 (389)

## Гарчиг

### Нэг. МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

583.	Олон нийтийн радио, телевизийн тухай	138
584.	Төрийн өмчөөс олон нийтийн өмчид эд хөрөнгө шилжүүлэх тухай	146
585.	Олон нийтийн радио телевизийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	147
586.	Олон нийтийн радио, телевизийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай	148

### Хоёр. МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

587.	Олон нийтийн радио, телевизийн тухай хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай	Дугаар 09	148
588.	Ерөнхийлөгчийн хоригийн тухай	Дугаар 16	149
589.	Тогтоолд өөрчлөлт оруулах тухай	Дугаар 17	149
590.	Ерөнхийлөгчийн хоригийн тухай	Дугаар 18	150
591.	Засгийн газрын зарим гишүүнийг огцруулах тухай	Дугаар 20	150

### Гурав. МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

592.	Бавуугийн Цэрэндоржид Монгол Улсын ардын багш цол хүртээх тухай	Дугаар 04	150
593.	Чойжилжавын Гунгаасүхэд Монгол Улсын ардын зураач цол хүртээх тухай	Дугаар 05	150
594.	Түвдийн Доржид Монгол Улсын шинжлэх ухааны гавъяат зүтгэлтэн цол хүртээх тухай	Дугаар 06	151
595.	Дэмбэрэлийн Булгад Монгол Улсын гавъяат багш цол хүртээх тухай	Дугаар 07	151
596.	Дамдинсүрэнгийн Нацагдоржид Монгол Улсын хүний гавъяат эмч цол хүртээх тухай	Дугаар 08	151
597.	Цэрэндоржийн Балдоржид Монгол Улсын соёлын гавъяат зүтгэлтэн цол хүртээх тухай	Дугаар 09	151
598.	Аюурзанын Долгорт Монгол Улсын ардын жүжигчин цол хүртээх тухай	Дугаар 11	152
599.	Шарын Чимэдцэвэд Монгол Улсын ардын жүжигчин цол хүртээх тухай	Дугаар 12	152
600.	Зарим хүмүүст Монгол Улсын гавъяат малчин цол хүртээх тухай	Дугаар 13	152

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2005 оны 1 дүгээр  
сарын 27-ны өдөр

Улаанбаатар  
хот

### ОЛОН НИЙТИЙН РАДИО, ТЕЛЕВИЗИЙН ТУХАЙ

#### НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

##### Нийтлэг үндэслэл

##### 1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

1.1. Энэ хуулийн зорилт нь Монголын ард түмэнд үйлчлэх олон нийтийн радио, телевизийг үүсгэн байгуулж, түүний зорилго, зохион байгуулалт, үйл ажиллагааны зарчим, эрх зүйн үндсийг тогтоож, хөтөлбөрийн бодлогын үндсийг тодорхойлоход оршино.

##### 2 дугаар зүйл. Олон нийтийн радио, телевизийн тухай хууль тогтоомж

2.1. Олон нийтийн радио, телевизийн тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль<sup>1</sup>, Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хууль<sup>2</sup>, энэ хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

##### 3 дугаар зүйл. Олон нийтийн радио, телевиз, түүний зорилго

3.1. Олон нийтийн радио, телевиз энэ хуулийн дагуу байгуулагдаж, гагцхүү олон нийтийн эрх ашигт үйлчилдэг, тэдний өмнө хариуцлага хүлээж, хяналт дор нь үйл ажиллагаагаа явуулдаг ашгийн төлөө бус хуулийн этгээд мөн.

3.2. Олон нийтийн радио, телевизийн зорилго нь үндэсний хэмжээнд өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхэлж, сонсогч, үзэгчдэд зориулсан төрөл бүрийн мэдээлэл, сургалт, танин мэдэхүй, хөгжөөн цэнгээх хөтөлбөр, нэвтрүүлэг бэлтгэх, нийтийн хүртээл болгоход оршино.

3.3. Олон нийтийн радио, телевиз гадаадын сонсогч, үзэгчдэд зориулсан өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхэлж, Монгол Улсын гадаад, дотоод бодлогын талаар мэдээлэх, Монгол орныг дэлхий дахинд сурталчлах, таниулах чиглэлийн хөтөлбөр, нэвтрүүлэг бэлтгэж түгээнэ.

3.4. Олон нийтийн радио, телевизийг зөвхөн хуулиар өөрчлөн байгуулж /нийлүүлэх, нэгтгэх, хуваах, тусгаарлах, өөрчлөх, татан буулгах/, үйл ажиллагааны зорилго, зарчмыг өөрчилж болно.

##### 4 дүгээр зүйл. Олон нийтийн радио, телевизийн үйл ажиллагааны үндсэн зарчим

4.1. Олон нийтийн радио, телевиз үйл ажиллагаандаа хараат бус байх, бодит мэдээлэл олж авах иргэний эрхийг хүндэтгэх, олон ургальч үзэл, ил тод байдлыг эрхэмлэх, аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтан, хувь хүн, улс төрийн намын эрх ашгийг бус нийт үндэсний эрх ашгийг дээдлэх үндсэн зарчмыг баримтална.

4.2. Олон нийтийн радио, телевиз дараахь үйл ажиллагаа явуулна:

4.2.1. үндэсний хэмжээнд радиогийн өргөн нэвтрүүлэг;

4.2.2. үндэсний хэмжээнд телевизийн өргөн нэвтрүүлэг;

4.2.3. гадаад хэлээр явуулах радио, телевизийн нэвтрүүлэг.

##### 5 дугаар зүйл. Олон нийтийн радио, телевизийн сурвалжлагч, редакцийн хараат бус байдлыг хангах

5.1. Олон нийтийн радио, телевизийн сурвалжлагч, редакци Үндсэн хууль болон энэ хуулийн үзэл санаанд нийцсэн нэвтрүүлэг бэлтгэх, нийтийн хүртээл болгоход нь аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтан, хувь хүн, олон нийтийн радио, телевизийн удирдлага хөндлөнгөөс оролцох, нөлөөлөхийг хориглоно.

5.2. Олон нийтийн радио, телевиз нь онц болон дайны байдал зарлагдсанаас бусад үед Монгол Улсын Ерөнхийлөгч, Монгол Улсын Их Хурлын дарга, Монгол Улсын Ерөнхий сайдаас ард түмэнд хандаж хэлэх үгийг дамжуулах эрхтэй.

##### 6 дугаар зүйл. Олон нийтийн радио, телевизийн үйл ажиллагааны ил тод байдал

6.1. Олон нийтийн радио, телевиз жил бүр үйл ажиллагааныхаа дэлгэрэнгүй тайланг өдөр тутмын сониноор, эсхүл нийтэд хүртээмжтэй бусад хэлбэрээр мэдээлэх бөгөөд тайланд дараахь мэдээллийг тусгана:

6.1.1. олон нийтийн радио, телевизийн хөтөлбөрийн бодлогын хэрэгжилт, нэвтрүүлгийн хөтөлбөрүүдийн тухай мэдээлэл;

6.1.2. санхүүгийн жилийн тайлан, аудиторын дүгнэлт;

<sup>1</sup> "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 1992 оны №1

<sup>2</sup> "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 1998 оны №10

6.1.3. олон нийтийн радио, телевизийн Ерөнхий захиралтай байгуулсан гэрсээний хэрэгжилт;

6.1.4. ирэх жилийн зорилт, хөтөлбөрт оруулах өөрчлөлтийн талаархи санал;

6.1.5. сонсогч, үзэгчдийн санал, хүсэлт, гомдлын талаархи мэдээлэл, тэдгээрийг шийдвэрлэсэн байдал.

6.2. Олон нийтийн радио, телевиз үйл ажиллагаагаа ил тод байлгах, олон нийтийн санаа бодлыг тусгах зорилгоор хэлэлцүүлэг явуулах, сонсогч, үзэгчидтэй уулзалт зохион байгуулах зэрэг арга хэмжээ авч хэрэгжүүлнэ.

## 7 дугаар зүйл. Олон нийтийн радио, телевизийг төрөөс дэмжих

7.1. Олон нийтийн радио, телевиз үйл ажиллагаагаа явуулахад нь төрөөс санхүү, эдийн засгийн зохих дэмжлэг үзүүлнэ.

7.2. Өргөн нэвтрүүлгээ улс орны хэмжээнд дамжуулах радио, телевизийн үндсэн сувгийг олон нийтийн радио, телевизэд хөнгөлөлттэй нөхцөлөөр, нэмэлт сувгийг Радио долгионы тухай хуулийн<sup>3</sup> дагуу төлбөртэйгээр ашиглуулж болно.

*/Энэ хэсэгт Монгол Улсын Ерөнхийлөгч 2005 оны 2 дугаар сарын 14-ний өдөр хориг тавьсан бөгөөд уг хоригийг Монгол Улсын Их Хурал хүлээн авч Олон нийтийн радио, телевизийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 2005 оны 2 дугаар сарын 17-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/*

7.3. Олон нийтийн радио, телевиз нэвтрүүлгээ газрын сүлжээ, хиймэл дагуул, кабель, интернэт болон бусад техник хэрэгсэл ашиглан дамжуулах эрхтэй.

## ХОЁРДУГААР БҮЛЭГ

### Олон нийтийн радио, телевизийн хөтөлбөр, зар сурталчилгаа

## 8 дугаар зүйл. Олон нийтийн радио, телевизийн хөтөлбөрийн бодлого

8.1. Олон нийтийн радио, телевиз улс төр, эдийн засаг, шинжлэх ухаан, боловсрол, соёл, урлаг, спорт зэрэг нийгмийн амьдралын олон талыг хамарсан хөтөлбөрийг техникийн болон мэргэжлийн өндөр түвшинд бэлтгэж нийтийн хүртээл болгоно.

8.2. Олон нийтийн радио, телевиз хөтөлбөрөө бэлтгэж түгээхдээ дараахь бодлого

баримтална:

8.2.1. ардчилал, шударга ёс, хүний эрх, эрх чөлөө, тэгш байдлыг хүндэтгэх;

8.2.2. улс төр, шашин, нийгэм, эдийн засгийн олон ургальч үзэл бодлыг хүндэтгэж, тэдгээрийг тэгш илэрхийлэх;

8.2.3. үндэсний соёл, урлаг, түүх, ёс заншил, уламжлалыг хүндэтгэх, үндэсний эв нэгдлийг эрхэмлэн дээдлэх, хүрээлэн байгаа орчноо хамгаалахыг дэмжих;

8.2.4. энх тайвныг сахин хамгаалахыг тууштай дэмжих, улс орнуудын хоорондын харилцан ойлголцол, итгэлцлийг бэхжүүлэх;

8.2.5. соёл, урлагийн хөгжилд бодитой хувь нэмэр оруулахуйц уран бүтээлийн бүх хэлбэрийг дэлгэрүүлэн хөгжүүлэх;

8.2.6. хувь хүний болон нийгмийн хөгжлийг дэмжих, ялангуяа хүүхэд, залуучуудын оюуны болон бие бялдрын хөгжилд онцгой анхаарах;

8.2.7. үндэстний цөөнх, эмэгтэйчүүд, хүүхдүүд, хөгжлийн бэрхшээлтэй иргэд зэрэг нийгмийн бүлэг, давхаргын болон олон нийтийн эрэлт хэрэгцээг тэнцвэртэй хангахыг эрмэлзэх.

8.3. Олон нийтийн радио, телевизээр харгислал, ялгаварлан гадуурхал, дайн, хүчирхийлэл, садар самууныг сурталчилсан, иргэний нэр төр, алдар хүнд, ажил эрхийн нэр хүндэд халдсан агуулгатай нэвтрүүлэг бэлтгэж түгээхийг хориглоно.

8.4. Олон нийтийн радио, телевизийн хөтөлбөрийн бодлого энэ хуульд нийцэж байгаа эсэхэд олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөл хяналт тавина.

8.5. Олон нийтийн радио, телевизийн хөтөлбөрийн талаар зөвлөх үүрэг бүхий орон тооны бус зөвлөлийг олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөл байгуулж болох бөгөөд уг зөвлөлийн бүрэлдэхүүнд сэтгүүл зүй, улс төр, эрх зүй, хэрэглэгчдийн эрх ашиг, боловсрол, соёл, шинжлэх ухаан, эрүүл мэнд, урлаг, шашин, байгаль орчин, спорт зэрэг чиглэлээр мэргэшсэн хүмүүсийг оруулна.

8.6. Энэ хуулийн 8.5-д заасан орон тооны бус зөвлөлийн ажиллах журмыг Олон нийтийн радио, телевизийн дүрэмд тусгана.

<sup>3</sup> Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 1999 оны №28

**9 дүгээр зүйл. Олон нийтийн радио, телевизийн хөтөлбөрт тавигдах тусгай шаардлага**

9.1. Олон нийтийн радио, телевизийн хөтөлбөр нь үнэн бодит мэдээлэл агуулсан, мэргэжлийн өндөр түвшинд бэлтгэгдсэн, нэг талыг баримтлаагүй, сэтгүүлчийн ёс зүйн зарчмыг баримталсан, шуурхай байна.

9.2. Олон нийтийн радио, телевизийн тухайн өдрийн хөтөлбөрт мэдээ, мэдээллийн болон сонсогч, үзэгчдийн танин мэдэхүйн хэрэгцээг хангахад чиглэгдсэн нэвтрүүлэг зохистой харьцаагаар тусгагдсан байна.

9.3. Олон нийтийн радио, телевизээр аливаа нийтлэл, нэвтрүүлгийг түгээхийн өмнө түүний агуулга, үүсэл, үнэн бодит байдлыг тухайн нийтлэл, нэвтрүүлгийг бэлтгэсэн сэтгүүлч, редакци шалгах ёстой бөгөөд тухайн мэдээ, мэдээлэл хуурамч болох нь илт мэдэгдэж байгаа, хуурамч гэдгийг мэдсэн, хуурамч гэж тооцох бодитой үндэслэл байгаа гэж үзвэл түүнийг түгээхгүй.

9.4. Олон нийтийн радио, телевиз хэвлэл, мэдээллийн бусад байгууллагын мэдээ, мэдээлэл, нэвтрүүлгийг дамжуулж байгаа бол эх сурвалжийг заавал дурдана.

9.5. Хуулиар хориглоогүй боловч хүүхэд, залуучуудын бие махбодь, оюун санаа, зан суртахуунд сөргөөр нөлөөлж болохуйц агуулга бүхий нэвтрүүлэг, баримтат болон уран сайхны киноны дамжуулах цагийг зохицуулах, эсхүл техникийн бусад арга хэмжээг ашиглах замаар хязгаарлалт тогтоож болно.

**10 дугаар зүйл. Олон нийтийн радио, телевизийн нэвтрүүлгийн баримтыг хадгалах**

10.1. Олон нийтийн радио, телевизээр нэвтрүүлсэн Монголын ард түмний амьдрал, хөгжлийн түүхийг тусгасан, эрдэм шинжилгээ, нийгэм, улс төр, эдийн засаг, соёлын ач холбогдолтой нэвтрүүлгийн баримтыг олон нийтийн радио, телевизийн архивт хадгална.

10.2. Олон нийтийн радио, телевизийн архив Үндэсний төв архивын салбар бөгөөд уг архивт архивын баримтыг бүрдүүлэх, хадгалах, хамгаалах, нөхөн бүрдүүлэх, ашиглахтай холбогдсон харилцааг Архивын тухай хуулиар<sup>4</sup> зохицуулна.

10.3. Олон нийтийн радио, телевизийн энэ хуулийн 10.1-т зааснаас бусад нэвтрүүлгийг тухайн

нэвтрүүлгийг дамжуулснаас хойш хоёр сараас доошгүй хугацаагаар хадгална.

**11 дүгээр зүйл. Олон нийтийн радио, телевизэд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх**

11.1. Олон нийтийн радио, телевизийн нэвтрүүлгийн техникийн болон мэргэжлийн чанартай холбогдуулан иргэд, байгууллагаас гаргасан өргөдөл, гомдлыг олон нийтийн радио, телевизийн Ерөнхий захирал ажлын 15 хоногийн дотор хянан шийдвэрлэж, бичгээр хариу өгнө.

11.2. Олон нийтийн радио, телевизийн нэвтрүүлгийн агуулгатай холбогдуулан иргэд, байгууллагаас гаргасан өргөдөл, гомдлыг олон нийтийн радио, телевизийн Өргөдлийг шалгах хороо хянан шийдвэрлэж, бичгээр хариу өгнө.

11.3. Олон нийтийн радио, телевизэд иргэд, байгууллагаас гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх журмыг Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх журмын тухай хуулийн<sup>5</sup> удирдлага болгон олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөл батална.

**12 дугаар зүйл. Нэвтрүүлэгт залруулга, тайлбар хийх**

12.1. Олон нийтийн радио, телевизээр худал, ташаа мэдээлэл хийгдсэн нь нотлох баримт, материалаар тогтоогдвол олон нийтийн радио, телевиз залруулга хийх үүрэгтэй.

12.2. Гомдол гаргагч шаардсан бол залруулга, тайлбарыг тухайн нэвтрүүлгийн дараагийн дугаараар, эсхүл нэн даруй ижил төрлийн нэвтрүүлгээр уг худал, ташаа мэдээллийн үргэлжилсэн цагаас илүүгүй хугацаагаар, үнэ төлбөргүй нийтэд хүргэнэ. Сэтгүүлчийн тайлбар нь мэдээ, мэдээллээс тодорхой ялгагдахуйц байна.

12.3. Олон нийтийн радио, телевизийн нэвтрүүлгийн агуулгын талаар нэвтрүүлгийг анх дамжуулснаас хойш нэг сарын дотор өргөдөл, гомдол гаргаж болох ба уг асуудлыг эцэслэн шийдвэрлэж дуустал тухайн нэвтрүүлгийн бичлэгийг хадгална.

**13 дугаар зүйл. Олон нийтийн радио, телевизээр нэвтрүүлэх зар сурталчилгаа**

13.1. Олон нийтийн радио, телевизээр нэвтрүүлэх зар сурталчилгаатай холбогдсон энэ хуулиар зохицуулаагүй харилцааг Зар сурталчилгааны тухай хуулиар<sup>6</sup> зохицуулна.

<sup>4</sup> "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 1998 оны №2

<sup>5</sup> "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 1995 оны №17

<sup>6</sup> "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 2002 оны №23

13.2. Олон нийтийн радио, телевизээр далд зар сурталчилгаа нэвтрүүлэхийг хориглоно.

13.3. Олон нийтийн радио, телевизээр нэвтрүүлэх зар сурталчилгаанд дараах тусгай шаардлагыг тавина:

13.3.1. хүүхдэд зориулсан нэвтрүүлгийн дундуур зөвхөн хүүхдэд зориулсан зар сурталчилгаа нэвтрүүлэх;

13.3.2. улс орны болон дэлхий дахины амьдралын цаг үеийн шинжтэй үйл явдлын талаархи тогтмол мэдээллийн хөтөлбөрийн дундуур зар сурталчилгаа нэвтрүүлэхгүй байх, мөн ийм мэдээллийн нэвтрүүлэгч зар сурталчилгаа бэлтгэх, бүтээх, дамжуулахад оролцохгүй байх;

13.3.3. сургалтын нэвтрүүлгийн дундуур зөвхөн сургалттай холбоотой бөгөөд 10 минутад 10 секундээс дээшгүй үргэлжлэх зар сурталчилгааг нэвтрүүлэх;

13.3.4. зар сурталчилгааны эхлэл, төгсгөлийг дуу, авиа, дүрсээр ялгахуйц байдлаар нэвтрүүлэх;

13.3.5. 20 минутаас дээшгүй үргэлжлэх нэвтрүүлгийн дундуур зар сурталчилгаа нэвтрүүлэхгүй байх.

13.4. Олон нийтийн радио, телевизээр нэвтрүүлэх зар сурталчилгааны нийт хугацаа тухайн өдрийн нэвтрүүлгийн цагийн хоёр хувиас хэтрэхгүй байна.

*Энэ зүйлд Монгол Улсын Ерөнхийлөгч 2005 оны 2 дугаар сарын 14-ний өдөр хориг тавьсан бөгөөд уг хоригийг Монгол Улсын Их Хурал хүлээн авч Олон нийтийн радио, телевизийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 2005 оны 2 дугаар сарын 17-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан!*

**14 дүгээр зүйл. Сонгуулийн сурталчилгаа**

14.1. Сонгуулийн үеэр нэвтрүүлэх сонгуулийн сурталчилгаатай холбогдсон харилцааг Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай<sup>7</sup>, Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай<sup>8</sup>, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай<sup>9</sup> хуулиар тус тус зохицуулна.

**15 дугаар зүйл. Нэвтрүүлгийг ивээн тэтгэх**

15.1. Олон нийтийн радио, телевизийн нэвтрүүлгийн агуулгад нөлөөлөхгүйгээр өөрийн үйлдвэрлэл, үйл ажиллагаа, бүтээгдэхүүний талаар бусдад мэдээлэл хүргэх зорилгоор аж ахуйн нэгж, байгууллага, иргэн нэвтрүүлгийг ивээн тэтгэж болно.

15.2. Нэвтрүүлгийн эхлэл, төгсгөлд нэвтрүүлэгчээс ивээн тэтгэсэн тухай мэдээллийг дурдах бөгөөд ивээн тэтгэсэн телевизийн нэвтрүүлгийн явцад ивээн тэтгэгчийн нэр, бэлгэдэл, хуулиар хориглоогүй бараа, үйлчилгээ, бүтээгдэхүүний дүрс зэргийг нэвтрүүлэгт саад учруулахгүйгээр дэлгэцийн аль нэг хэсэгт жижгээр гаргаж болно.

15.3. Ивээн тэтгэж байгаа аж ахуйн нэгж, байгууллага, иргэний бараа, ажил, үйлчилгээг худалдан авахыг тухайн нэвтрүүлгийн үеэр уриалах, сурталчлахыг хориглоно.

15.4. Улс орны болон дэлхий дахины амьдралын цаг үеийн шинжтэй үйл явдлын талаархи тогтмол мэдээллийн хөтөлбөрийг ивээн тэтгэхийг болон хуулиар сурталчлахыг хориглосон бараа, бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг, ажил, үйлчилгээ эрхэлдэг хуулийн этгээд аливаа нэвтрүүлгийг ивээн тэтгэхийг хориглоно.

## ГУРАВДУГААР БҮЛЭГ

**Олон нийтийн радио, телевизийн өмч, эд хөрөнгө, санхүүжилт**

**16 дугаар зүйл. Олон нийтийн радио, телевизийн өмч**

16.1. Олон нийтийн радио, телевизийн өмч нь олон нийтийн өмч мөн. Олон нийтийн радио, телевизид үйл ажиллагаагаа явуулахад шаардагдах төрийн өмчийн олон нийтийн радио, телевизийн өмчлөлд шилжүүлэх харилцааг бие даасан хуулиар зохицуулна.

16.2. Олон нийтийн радио, телевиз эд хөрөнгөө эзэмших, ашиглах, захиран зарцуулахдаа энэ хуулийн 3.2-т заасан зорилгыг хэрэгжүүлэхэд чиглүүлнэ.

**17 дугаар зүйл. Олон нийтийн радио, телевизийн санхүүжилт**

17.1. Олон нийтийн радио, телевизийн санхүүжилт дараах эх үүсвэрээс бүрдэнэ:

17.1.1. радио, телевизийн нэвтрүүлгийн үйлчилгээний хөлс;

17.1.2. зар сурталчилгаанаас олсон орлого;

<sup>7</sup> "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 1992 оны №2

<sup>8</sup> "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 1993 оны №3

<sup>9</sup> "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 1996 оны №10

*Гэвч заалтад Монгол Улсын Ерөнхийлөгч 2005 оны 2 дугаар сарын 14-ний өдөр хориг тавьсан бөгөөд уг хоригийг Монгол Улсын Их Хурал хүлээн аваагүй!*

17.1.3. тоног төхөөрөмж, бусад эд хөрөнгөө түрээслүүлсний орлого;

17.1.4. Монгол Улсын болон гадаадын иргэн, хуулийн этгээд, харьяалалгүй хүнээс өгсөн хандив, тусламж;

17.1.5. улсын төсвийн дэмжлэг;

17.1.6. хууль тогтоомжид заасан бусад эх үүсвэр.

**18 дугаар зүйл. Олон нийтийн радио, телевизийн нэвтрүүлгийн үйлчилгээний хөлс, түүний хэмжээ**

18.1. Олон нийтийн радио, телевизийн нэвтрүүлгийн үйлчилгээний хөлсийг нийтийн антени, өөрийн сансрын хүлээн авах, нэвтрүүлэх станц, кабелийн телевизийн шугамтай эсэхээс үл хамааран айл өрхөд болон байгууллага, аж ахуйн нэгжид радио-хүлээн авагч, телевизор тус бүрээр тооцон ногдуулна.

18.2. Олон нийтийн радио, телевизийн нэвтрүүлгийн үйлчилгээний хөлсний хэмжээг олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлийн саналыг үндэслэн Засгийн газар тогтооно.

18.3. Олон нийтийн радио, телевиз нэвтрүүлгийн үйлчилгээний хөлсийг улсын хэмжээнд хурааж төвлөрүүлэх үүрэг бүхий нэгжийг байгуулж болох бөгөөд түүний үйл ажиллагаа, санхүүжилтийн журмыг олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөл тогтооно.

18.4. Олон нийтийн радио, телевиз нэвтрүүлгийн үйлчилгээний хөлс төлөөгүй этгээдээс холбогдох хууль тогтоомжид заасан журмын дагуу нэхэмжлэх эрхтэй.

**19 дүгээр зүйл. Олон нийтийн радио, телевизийн санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд тавих хөндлөнгийн хяналт**

19.1. Олон нийтийн радио, телевизийн санхүүгийн тайланг шалгуулж баталгаажуулах, санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд бүрэн болон хэсэгчилсэн хөндлөнгийн шалгалт хийх зорилгоор гэрээний үндсэн дээр аудит хийлгэнэ.

19.2. Аудиторыг Үндэсний зөвлөл сонгож, түүнтэй гэрээ байгуулна.

## ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

**Олон нийтийн радио, телевизийн удирдлага, зохион байгуулалт**

**20 дугаар зүйл. Олон нийтийн радио, телевизийн удирдах дээд байгууллага**

20.1. Олон нийтийн радио, телевизийн удирдах дээд байгууллага нь олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөл /цаашид "Үндэсний зөвлөл" гэнэ/ байна.

**21 дүгээр зүйл. Үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүн, түүнийг сонгох**

21.1. Үндэсний зөвлөл нь олон нийтийн ашиг сонирхлыг төлөөлөх орон тооны бус байгууллага бөгөөд 17 гишүүнтэй байна.

21.2. Үндэсний зөвлөлийн гишүүний бүрэн эрхийн хугацаа 6 жил байна.

21.3. Үндэсний зөвлөлийн гишүүнд дараахь этгээдийг нэр дэвшүүлэхгүй:

21.3.1. улс төрийн болон төрийн жинхэнэ албан хаагч;

21.3.2. улс төрийн намын удирдах албан тушаалтан;

21.3.3. бусад радио, телевизэд ажиллаж байгаа, түүнчлэн ажилладаггүй боловч хөтөлбөрийн бодлогыг тодорхойлоход нь оролцдог этгээд;

21.3.4. бусад радио, телевизэд хөрөнгө оруулалт хийсэн этгээд, эсхүл олон нийтийн радио, телевизийн санхүүгийн хараат бус байдалд нөлөөлж болох этгээд.

21.4. Үндэсний зөвлөлийн гишүүнээр олон нийтэд нэр хүндтэй, ял шийтгэлгүй, Монгол Улсын иргэнийг сонгоно. Үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүнд удирдлага, эдийн засаг, санхүү, техник, технологи, эрх зүй, сэтгүүл зүй зэрэг чиглэлээр мэргэшсэн хүнийг заавал оруулна.

21.5. Үндэсний зөвлөлийн гишүүнээр энэ хуулийн 21.3, 21.4-т заасан шалгуурыг удирдлага болгон дор дурдсан байгууллага, албан тушаалтан өөрийн төлөөллийн хүнийг сонгоно:

21.5.1. Монгол Улсын Ерөнхийлөгч 2 хүн;

21.5.2. Монгол Улсын Их Хурал 4 хүн;

21.5.3. Монгол Улсын Засгийн газар 2 хүн.

21.6. Монгол Улсын хуулиар үйл ажиллагааны эрх зүйн үндэс нь тодорхойлогдсон төрийн бус байгууллагууд хоорондоо зөвшилцөх замаар 9 хүнийг сонгоно.

21.7. Энэ хуулийн 21.5, 21.6-д заасны дагуу сонгогдсон хүмүүсийн бүрэн эрхийг Үндэсний зөвлөл баталгаажуулна.

21.8. Үндэсний зөвлөлийн гишүүний бүрэн эрхийн хугацаа дуусахад дараагийн гишүүний нэр

дэвшүүлэх болон гишүүнийг нөхөн сонгох журмыг Үндэсний зөвлөл батална.

*/Энэ зүйлд Монгол Улсын Ерөнхийлөгч 2005 оны 2 дугаар сарын 14-ний өдөр хориг тавьсан бөгөөд уг хоригийг Монгол Улсын Их Хурал хүлээн авч Олон нийтийн радио, телевизийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 2005 оны 2 дугаар сарын 17-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/*

## 22 дугаар зүйл. Үндэсний зөвлөлийн анхны хуралдаан

22.1. Үндэсний зөвлөлийн анхны хуралдаанаар дараахь асуудлыг хэлэлцэн шийдвэрлэнэ:

22.1.1. Үндэсний зөвлөлийн гишүүдийн бүрэн эрхийг баталгаажуулах;

22.1.2. Үндэсний зөвлөлийн даргыг сонгох;

22.1.3. Хяналтын зөвлөл, Өргөдлийг шалгах хороог байгуулах.

22.2. Үндэсний зөвлөлийн үйл ажиллагааг тасралтгүй явуулах, түүний залгамж чанарыг хадгалах зорилгоор анхны гишүүдийн наймыг нь 3 жилээр, есийг нь 6 жилээр сонгож, цаашид энэ хуулийн 21.2-т заасан хугацааг баримтална.

22.3. Үндэсний зөвлөлийн анхны гишүүдийн энэ хуулийн 22.2-т заасан хугацааг сугалаагаар шийдвэрлэнэ.

## 23 дугаар зүйл. Үндэсний зөвлөлийн дарга

23.1. Үндэсний зөвлөлийн даргад сонгох хүнийг Үндэсний зөвлөлийн гишүүд дотроосоо нэр дэвшүүлэн нууц санал хураалтаар Үндэсний зөвлөлийн нийт гишүүдийн олонхийн саналаар сонгоно.

23.2. Үндэсний зөвлөлийн даргад гурав буюу түүнээс дээш хүний нэр дэвшиж анхны санал хураалтаар хэн нь ч Үндэсний зөвлөлийн нийт гишүүдийн олонхийн саналыг аваагүй бол хамгийн олон санал авсан хоёр хүнийг дахин санал хураалтад оруулж, Үндэсний зөвлөлийн нийт гишүүдийн олонхийн санал авсан гишүүнийг Үндэсний зөвлөлийн даргаар сонгогдсонд тооцно.

23.3. Үндэсний зөвлөлийн даргын бүрэн эрхийн хугацаа 3 жил байх бөгөөд түүнийг нэг удаа улируулан сонгож болно.

23.4. Үндэсний зөвлөлийн дарга нас барсан, түүнийг энэ хуулийн 26 дугаар зүйлд заасны дагуу эгүүлэн татсан бол гишүүдийн хамгийн ахмад нь шинэ даргыг сонгох хүртэл үүргийг нь гүйцэтгэнэ. Үндэсний зөвлөлийн даргын түр эзгүйд түүний санал

болгосон гишүүн, хэрэв санал болгоогүй бол гишүүдийн хамгийн ахмад нь орлоно.

23.5. Үндэсний зөвлөлийн дарга Үндэсний зөвлөлийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулж, түүний шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавина.

## 24 дүгээр зүйл. Үндэсний зөвлөлийн бүрэн эрх

24.1. Үндэсний зөвлөл дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

24.1.1. Олон нийтийн радио, телевизийн дүрэм болон тэнд ажиллагсдын ёс зүйн дүрэм батлах, нэмэлт, өөрчлөлт оруулах;

24.1.2. олон нийтийн радио, телевизийн үйл ажиллагааны үндсэн зорилт, стратеги төлөвлөгөө, тухайн жилийн төсвийн төслийг хэлэлцэх, Монгол Улсын төсөвт тусгуулах;

24.1.3. олон нийтийн радио, телевизийн техник, технологийн сүлжээг хөгжүүлэх, техникийн хангамжийн бодлогыг тодорхойлох;

24.1.4. олон нийтийн радио, телевизийн Хяналтын зөвлөл, Өргөдлийг шалгах хороог байгуулах, тэдгээрийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах;

24.1.5. олон нийтийн радио, телевизийн хөтөлбөр энэ хуульд нийцэж байгаа эсэхэд хяналт тавих;

24.1.6. олон нийтийн радио, телевизийн зохион байгуулалтын бүтэц, орон тооны дээд хязгаарыг тогтоох;

24.1.7. олон нийтийн радио, телевизийн Ерөнхий захиралд нэр дэвшүүлэх, томилох журмыг батлах;

24.1.8. олон нийтийн радио, телевизийн Ерөнхий захирлыг энэ хуульд заасан журмын дагуу томилох, чөлөөлөх, түүнтэй гэрээ байгуулах;

24.1.9. олон нийтийн радио, телевизийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг хэлэлцэж батлах;

24.1.10. олон нийтийн радио, телевизийн дэд захирал, зохион байгуулалтын нэгжийн даргыг сонгон шалгаруулах журмыг батлах;

24.1.11. энэ хууль болон Олон нийтийн радио, телевизийн дүрэмд заасан бусад бүрэн эрх.

24.2. Үндэсний зөвлөл нь нарийн бичгийн

даргатай байна. Нарийн бичгийн дарга нь орон тооны байна.

## 25 дугаар зүйл. Үндэсний зөвлөлийн хуралдаан

25.1. Үндэсний зөвлөлийн үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь Үндэсний зөвлөлийн хуралдаан байна.

25.2. Үндэсний зөвлөлийн ээлжит хуралдааныг улиралд нэгээс доошгүй удаа хийнэ.

25.3. Үндэсний зөвлөлийн ээлжит бус хуралдааныг Үндэсний зөвлөлийн даргын, эсхүл гишүүдийн гуравны нэгээс доошгүйн санаачилгаар хийнэ.

25.4. Үндэсний зөвлөлийн хуралдааныг Үндэсний зөвлөлийн дарга, түүний эзгүйд орлож байгаа гишүүн даргална.

25.5. Үндэсний зөвлөлийн хуралдааныг Үндэсний зөвлөлийн гишүүдийн дийлэнх олонхи буюу гуравны хоёроос доошгүй нь хүрэлцэн ирснээр хүчинтэйд тооцно.

25.6. Хуралдаанаар хэлэлцсэн асуудлыг хуралдаанд оролцсон Үндэсний зөвлөлийн гишүүдийн олонхийн саналаар шийдвэрлэнэ.

25.7. Үндэсний зөвлөлийн хуралдааны явцын тухай тэмдэглэл хөтлөх бөгөөд тэмдэглэлийг Үндэсний зөвлөлийн нарийн бичгийн дарга хөтөлж гарын үсэг зурна.

25.8. Үндэсний зөвлөл шийдвэрлэсэн асуудлаараа тогтоол гаргах бөгөөд түүнд Үндэсний зөвлөлийн дарга гарын үсэг зурна.

25.9. Үндэсний зөвлөлийн хуралдааны явц, шийдвэрийн талаар олон нийтэд хэвлэл мэдээллийн хэрэгслээр тухай бүр мэдээлнэ.

## 26 дугаар зүйл. Үндэсний зөвлөлийн дарга, гишүүнийг эгүүлэн татах

26.1. Үндэсний зөвлөлийн дарга, гишүүнийг бүрэн эрхийн хугацаа дуусахаас өмнө дараахь үндэслэлээр эгүүлэн татна:

26.1.1. эрүүл мэндийн байдал, хүндэтгэн үзэх бусад шалтгаанаар чөлөөлж өгөхийг хүүссэн өргөдлийг Үндэсний зөвлөлийн дарга, гишүүн гаргасан;

26.1.2. гэмт хэрэг үйлдсэн нь нотлогдож шүүхийн шийтгэх тогтоол хүчин төгөлдөр болсон;

26.1.3. энэ хуулийн 21.3-т заасныг зөрчсөн нь сонгогдсоных нь дараа илэрсэн;

26.1.4. энэ хуулийн 21.3-т заасан ажил, албан тушаалд томилогдсон буюу сонгогдсон;

26.1.5. Үндэсний зөвлөлийн хуралдаанд 6 сараас дээш хугацаагаар биечлэн оролцоогүй.

26.2. Энэ хуулийн 26.1-д заасан эгүүлэн татах үндэслэл бий болсон бол Хяналтын зөвлөл зөвлөмж гарган, уг гишүүнийг сонгосон байгууллагад мэдэгдэнэ.

26.3. Үндэсний зөвлөлийн дарга, гишүүнийг эгүүлэн татах тухай Хяналтын зөвлөлийн зөвлөмж гарсны дараа тухайн гишүүн Үндэсний зөвлөлийн хуралдаанд оролцохгүй.

26.4. Үндэсний зөвлөлийн дарга, гишүүнийг эгүүлэн татах шийдвэрийг түүнийг сонгосон байгууллага гаргана.

## 27 дугаар зүйл. Үндэсний зөвлөлийн дарга, гишүүний ажиллах баталгаа

27.1. Үндэсний зөвлөлийн дарга, гишүүнийг энэ хуулийн 26.1-д зааснаас бусад үндэслэлээр бүрэн эрхийн хугацаа дуусахаас өмнө эгүүлэн татахгүй.

27.2. Үндэсний зөвлөлийн дарга, гишүүнд Үндэсний зөвлөлийн нийт гишүүдийн үндсэн ажлынх нь цалин, түүнтэй адилтгах бусад орлогын дунджийн 40 хувиас хэтрэхгүй хэмжээний урамшуулал олгох бөгөөд урамшууллын хэмжээ, олгох журмыг Үндэсний зөвлөл батална.

27.3. Үндэсний зөвлөлийн дарга, гишүүн энэ хуульд заасан үүрэгт ажлаа гүйцэтгэхэд түүнийг ажиллаж байгаа үндсэн байгууллага дэмжлэг, тусламж үзүүлэх үүрэгтэй.

## 28 дугаар зүйл. Хяналтын зөвлөл

28.1. Олон нийтийн радио, телевизийн хөтөлбөрийн бодлогоос бусад асуудлаар гарсан Үндэсний зөвлөлийн шийдвэрийн хэрэгжилт, олон нийтийн радио, телевизийн санхүү, аж ахуйн үйл ажиллагаа, менежментэд хяналт тавих чиг үүрэг бүхий Хяналтын зөвлөл ажиллана.

28.2. Хяналтын зөвлөлийн дарга, гишүүдийг Үндэсний зөвлөл 3 хүний бүрэлдэхүүнтэйгээр сонгох бөгөөд Хяналтын зөвлөлийн ажиллах журмыг Үндэсний зөвлөл батална.

28.3. Хяналтын зөвлөлийг ажиллах нөхцөлөөр хангах үүргийг олон нийтийн радио, телевизийн Ерөнхий захирал хүлээнэ.

## 29 дүгээр зүйл. Хяналтын зөвлөлийн эрх, үүрэг

29.1. Хяналтын зөвлөл дараахь эрх, үүрэгтэй:

29.1.1. Үндэсний зөвлөлийн дарга, гишүүнийг эгүүлэн татах тухай зөвлөмж гаргах;

29.1.2. хөтөлбөрийн бодлогоос бусад асуудлаар олон нийтийн радио, телевизийн Ерөнхий захиралд зөвлөх;

29.1.3. олон нийтийн радио, телевизийн санхүү, аж ахуйн үйл ажиллагаа, менежмент, төсвийн төсөл, санхүүгийн жилийн тайланд дүгнэлт хийж, Үндэсний зөвлөлөөр хэлэлцүүлэх;

29.1.4. хөрөнгө оруулалт, төсөв, хүний нөөцийн бодлогод нөлөөлөхүйц санхүүгийн гэрээ, хэлэлцээрийг бусад аж ахуйн нэгж, байгууллага, иргэнтэй байгуулах асуудлаар санал боловсруулж, Үндэсний зөвлөлд танилцуулах;

29.1.5. олон нийтийн радио, телевизийн Ерөнхий захирлын санхүү, аж ахуйн үйл ажиллагааг хянан шалгах, баримтын шалгалт хийх, дүнг Үндэсний зөвлөлд оруулж хэлэлцүүлэх.

### 30 дугаар зүйл. Өргөдлийг шалгах хороо

30.1. Олон нийтийн радио, телевизийн нэвтрүүлгийн агуулгатай холбогдуулан Үндэсний зөвлөлд ирүүлсэн өргөдөл, гомдлыг хянан шийдвэрлэх, олон нийтийн санва бодлыг судлах чиг үүрэг бүхий Өргөдлийг шалгах хороог Үндэсний зөвлөл байгуулан ажиллуулна.

30.2. Өргөдлийг шалгах хороо нь Үндэсний зөвлөлийн гишүүд болон хүний эрх, сэтгүүл зүй, эрх зүйн чиглэлээр мэргэшсэн хүмүүсээс бүрдэнэ.

30.3. Өргөдлийг шалгах хорооны бүтэц, бүрэлдэхүүн, ажиллах журмыг Үндэсний зөвлөл батална.

### 31 дүгээр зүйл. Олон нийтийн радио, телевизийн Ерөнхий захирал, түүний бүрэн эрх

31.1. Олон нийтийн радио, телевизийн Ерөнхий захирал /цаашид "Ерөнхий захирал" гэнэ/-ыг Үндэсний зөвлөлийн нийт гишүүдийн олонхийн саналаар, нууц санал хураалтаар 3 жилийн хугацаагаар томилно.

31.2. Ерөнхий захирлыг сонгон шалгаруулах замаар томилж болно.

31.3. Ерөнхий захирлаар дээд боловсролтой, ял шийтгэлгүй, улс төрийн намын гишүүн бус хүнийг томилно.

31.4. Ерөнхий захирал Үндэсний зөвлөлийн гишүүн байж болохгүй.

31.5. Ерөнхий захирал бусад байгууллага, аж ахуйн нэгжийн удирдлагын бүрэлдэхүүнд хавсран ажиллаж болохгүй.

31.6. Ерөнхий захирал дор дурдсан бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

31.6.1. олон нийтийн радио, телевизийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулах;

31.6.2. энэ хуулиар тодорхойлсон хөтөлбөрийн бодлогын хүрээнд нэвтрүүлгийн хөтөлбөрийг тогтоох;

31.6.3. Үндэсний зөвлөлөөс олгосон эрх хэмжээний хүрээнд олон нийтийн радио, телевизийн эд хөрөнгийг захиран зарцуулах;

31.6.4. олон нийтийн радио, телевизийн үйл ажиллагааны стратеги төлөвлөгөө, тухайн жилийн төсвийн төсөл, гүйцэтгэл болон тайланг Үндэсний зөвлөлөөр хэлэлцүүлэх;

31.6.5. олон нийтийн радио, телевизийн дэд захирал, зохион байгуулалтын нэгжийн даргын сонгон шалгаруулалтын дүнг Үндэсний зөвлөлд танилцуулсны үндсэн дээр тэднийг томилох;

31.6.6. олон нийтийн радио, телевизийн ажилтнуудтай хөдөлмөрийн гэрээ байгуулах, цуцлах;

31.6.7. Үндэсний зөвлөлөөс олгосон эрх хэмжээний хүрээнд гэрээ, хэлцэл хийх, олон нийтийн радио, телевизийг гадаад, дотоодод төлөөлөх;

31.6.8. тогтоосон журмын дагуу нягтлан бодох бүртгэл хөтлөх, тайлан тэнцэл, статистикийн мэдээ гаргах ажлыг зохион байгуулах.

31.7. Хяналтын зөвлөлийн зөвшөөрлийг үндэслэн Ерөнхий захирал олон нийтийн радио, телевизийн зарим ажил, үйлчилгээг аж ахуйн нэгж, байгууллага, иргэнээр гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлж болно.

### ТАВДУГААР БҮЛЭГ

#### Орон нутгийн олон нийтийн радио, телевиз

32 дугаар зүйл. Орон нутгийн олон нийтийн радио, телевизийн үйл ажиллагаа

32.1. Орон нутагт олон нийтийн радио, телевиз /цаашид "орон нутгийн радио, телевиз" гэнэ/ байж болно.

32.2. Орон нутгийн радио, телевиз энэ хуульд заасан зарчмын дагуу байгуулагдаж, тухайн орон нутгийн иргэдийн нийтлэг эрх ашигт үйлчилж, тэдний өмнө хариуцлага хүлээж, хяналт дор нь үйл ажиллагаа явуулна.

32.3. Орон нутгийн радио, телевизийн ажиллах бүтэц, зохион байгуулалт, санхүүжилт болон үйл ажиллагаа явуулах журмыг аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал батална.

32.4. Олон нийтийн радио, телевиз орон нутгийн радио, телевизэд үйл ажиллагааны талаар арга зүйн туслалцаа үзүүлнэ.

### 33 дугаар зүйл. Орон нутгийн радио, телевизийн хараат бус байдал

33.1. Орон нутгийн радио, телевиз тухайн орон нутгийн засаг захиргааны байгууллага, албан тушаалтнаас хараат бусаар ажиллана.

33.2. Орон нутгийн радио, телевизэд тухайн орон нутгийн төсвөөс санхүүгийн зохих дэмжлэг үзүүлж болно.

33.3. Орон нутгийн радио, телевиз нэвтрүүлгийн онцлог, нэвтрүүлэх цагаас хамаарч үйлчилгээний хураамжийг өөрсдөө тогтоох ба энэ хуулийн 18.3-г заасан нэгжтэй хамтран ажиллаж болно.

## ЗУРГАДУГААР БҮЛЭГ

### Бусад

#### 34 дүгээр зүйл. Мэдээлэл олж авах, мэдээллийн эх сурвалжийг нууцлах

34.1. Олон нийтийн радио, телевизийн ажилтан төр, байгууллага болон хувь хүний нууцтай холбоотойгоос бусад мэдээллийг олж авах, нийтийн хүртээл болгох эрхтэй.

34.2. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, нийтийн ашиг сонирхол хөндөгдсөн гэж шүүх үзэж ил болгосноос бусад тохиолдолд олон нийтийн радио, телевизийн ажилтан мэдээллийн эх сурвалжийг нууцлах эрхтэй.

#### 35 дугаар зүйл. Улсын бүртгэлд бүртгүүлэх

35.1. Энэ хуульд заасны дагуу Үндэсний зөвлөлийн гишүүдийг сонгож, уг зөвлөлийн анхны хуралдаан хийснээс хойш 30 хоногийн дотор Үндэсний зөвлөлийн дарга Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд<sup>10</sup> заасны дагуу олон нийтийн радио, телевизийг улсын бүртгэлд бүртгүүлнэ.

#### 36 дугаар зүйл. Хууль хүчин төгөлдөр болох

36.1. Энэ хуулийг 2005 оны 4 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДЭД  
ДАРГА

Д.ЛҮНДЭЭЖАНЦАН

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2005 оны 1 дүгээр сарын 27-ны өдөр

Улаанбаатар хот

### ТӨРИЙН ӨМЧӨӨС ОЛОН НИЙТИЙН ӨМЧИД ЭД ХӨРӨНГӨ ШИЛЖҮҮЛЭХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Радио, телевизийн хэрэг эрхлэх газрын эзэмшилд байгаа дамжуулах, дахин дамжуулах техник, станц болон үндэсний радио, телевизийн архивыг төрийн өмчид хэвээр үлдээсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийн 1 дүгээр зүйлд зааснаас бусад Радио, телевизийн хэрэг эрхлэх газрын эзэмшилд байгаа 2005 оны 1 дүгээр сарын 1-ний өдрийн байдлаар тодорхойлогдсон 5.248.189.587 төгрөгийн үндсэн, 272.873.442 төгрөгийн эргэлтийн, бүгд 5.521.063.029 төгрөгийн төрийн өмчийн эд хөрөнгийг шинээр байгуулагдах Олон нийтийн радио, телевизийн өмчлөлд шилжүүлсүгэй.

3 дугаар зүйл. Энэ хуулийг Олон нийтийн радио, телевизийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

*Энэ хуульд Монгол Улсын Ерөнхийлөгч 2005 оны 2 дугаар сарын 14-ний өдөр хориг тавьсан бөгөөд уг хоригийг Монгол Улсын Их Хурал хүлээн аваагүй!*

МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДЭД  
ДАРГА

Д.ЛҮНДЭЭЖАНЦАН

<sup>10</sup> "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 2003 оны №22

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2005 оны 2 дугаар сарын 17-ны өдөр

Улаанбаатар хот

### ОЛОН НИЙТИЙН РАДИО, ТЕЛЕВИЗИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Олон нийтийн радио, телевизийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 13, 21 дүгээр зүйлийг дор дурдсанаар тус тус өөрчлөн найруулсугай:

1/ 7 дугаар зүйлийн 2 дахь хэсэг:

"7.2. Өргөн нэвтрүүлгээ улс орны хэмжээнд дамжуулах радио, телевизийн үндсэн сувгийг олон нийтийн радио, телевизэд хөнгөлөлттэй нөхцөлөөр ашиглуулна. Нэмэлт сувгийг Радио долгионы тухай хуулийн дагуу төлбөртэйгээр ашиглуулж болох бөгөөд уг сувгийг энэ хуулийн 3.2, 3.3, 8, 9 дүгээр зүйлд заасан зорилго, бодлого, шаардлагад нийцүүлэн ашиглана."

2/13 дугаар зүйл:

**"13 дугаар зүйл. Олон нийтийн радио, телевизээр нэвтрүүлэх зар сурталчилгаа**

13.1. Олон нийтийн радио, телевизээр арилжааны болон далд зар сурталчилгаа нэвтрүүлэхийг хориглоно.

13.2. Олон нийтийн радио, телевизээр нэвтрүүлэх зар сурталчилгаанд дараахь тусгай шаардлагыг тавина:

13.2.1. хүүхдэд зориулсан нэвтрүүлгийн дундуур зөвхөн хүүхдэд зориулсан зар сурталчилгаа нэвтрүүлэх;

13.2.2. улс орны болон дэлхий дахины амьдралын цаг үеийн шинжтэй үйл явдлын талаархи тогтмол мэдээллийн хөтөлбөрийн дундуур зар сурталчилгаа нэвтрүүлэхгүй байх, мөн ийм мэдээллийн нэвтрүүлэгч зар сурталчилгаа бэлтгэх, бүтээх, дамжуулахад оролцохгүй байх;

13.2.3. сургалтын нэвтрүүлгийн дундуур зөвхөн сургалттай холбоотой бөгөөд 10 минутад 10 секундээс дээшгүй үргэлжлэх зар сурталчилгааг нэвтрүүлэх;

13.2.4. зар сурталчилгааны эхлэл, төгсгөлийг дуу, авиа, дүрсээр ялгахуйц байдлаар нэвтрүүлэх;

13.2.5. 20 минутаас дээшгүй үргэлжлэх нэвтрүүлгийн дундуур зар сурталчилгаа нэвтрүүлэхгүй байх.

13.3. Олон нийтийн радио, телевизээр нэвтрүүлэх зар сурталчилгааны нийт хугацаа тухайн өдрийн нэвтрүүлгийн цагийн хоёр хувиас хэтрэхгүй байна.

13.4. Олон нийтийн радио, телевизээр нэвтрүүлэх зар сурталчилгаатай холбогдсон бусад харилцааг Зар сурталчилгааны тухай хуулиар зохицуулна."

3/ 21 дүгээр зүйл:

**"21 дүгээр зүйл. Үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүн, түүнийг томилох**

21.1. Үндэсний зөвлөл нь олон нийтийн ашиг сонирхлыг төлөөлөх орон тооны бус байгууллага бөгөөд 15 гишүүнтэй байна.

21.2. Үндэсний зөвлөлийн гишүүний бүрэн эрхийн хугацаа 6 жил байна.

21.3. Үндэсний зөвлөлийн гишүүнд дараахь этгээдийг нэр дэвшүүлэхгүй:

21.3.1. төрийн улс төрийн болон төрийн жинхэнэ албан хаагч;

21.3.2. улс төрийн намын удирдах албан тушаалтан;

21.3.3. бусад радио, телевизэд ажиллаж байгаа, түүнчлэн ажилладаггүй боловч хөтөлбөрийн бодлогыг тодорхойлоход нь оролцдог этгээд;

21.3.4. бусад радио, телевизэд хөрөнгө оруулалт хийсэн этгээд, эсхүл олон нийтийн радио, телевизийн санхүүгийн хараат бус байдалд нөлөөлж болох этгээд.

21.4. Үндэсний зөвлөлийн гишүүнээр ял шийтгэлгүй, иргэний нийгмийн төлөөлөөс санал болгосон Монгол Улсын иргэнийг томилно.

21.5. Энэ хуулийн 21.3, 21.4-т заасан шалгуурыг удирдлага болгон дор дурдсан байгууллага, албан тушаалтан Үндэсний зөвлөлийн гишүүнд нэр дэвшүүлнэ:

21.5.1. Монгол Улсын Ерөнхийлөгч

4 хүн;

21.5.2. Монгол Улсын Их Хурал 7

хүн;

4 хүн.	21.5.3. Монгол Улсын Засгийн газар	21.9. Нэр дэвшсэн хүнийг Улсын Их Хурал Үндэсний зөвлөлийн гишүүнээр томилоогүй бол нэр дэвшүүлсэн байгууллага, албан тушаалтан өөр хүний нэр дэвшүүлнэ.
21.6. Үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүнд оруулахаар түүх уламжлал, ёс заншил, соёл урлаг, утга зохиол, шинжлэх ухааны чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагууд тухайн чиглэлээр мэргэшсэн хүний нэрийг Монгол Улсын Ерөнхийлөгчид; эрх зүй, гадаад харилцаа, сэтгүүл зүй, эрүүл мэнд, боловсрол, биеийн тамир, спорт, байгаль орчин, хөдөлмөр, нийгмийн хамгааллын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагууд тухайн чиглэлээр мэргэшсэн хүний нэрийг Улсын Их Хуралд; эдийн засаг, бизнес, техник технологи, удирдлага менежментийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагууд тухайн чиглэлээр мэргэшсэн хүний нэрийг Засгийн газарт тус тус санал болгоно.	21.10. Үндэсний зөвлөлийн гишүүн Монгол Улсын Ерөнхийлөгч, Монгол Улсын Их Хурал болон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд нэр дэвшсэн тохиолдолд түүнийг Үндэсний зөвлөлийн гишүүнээс чөлөөлнө.	
21.7. Энэ хуулийн 21.5-д заасан байгууллага, албан тушаалтан төрийн бус байгууллагуудын саналаас сонголт хийн Үндэсний зөвлөлийн гишүүнд нэр дэвшүүлж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ.	2 дугаар зүйл. Олон нийтийн радио, телевизийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн "наймыг" гэснийг "долоог", "есийг" гэснийг "наймыг" гэж, 36 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн "4 дүгээр сарын 1-ний өдрөөс" гэснийг "7 дугаар сарын 1-ний өдрөөс" гэж тус тус өөрчилсүгэй.	
21.8. Энэ хуулийн 21.7-д заасны дагуу нэр дэвшсэн хүмүүсийг Улсын Их Хурал хэлэлцэж Үндэсний зөвлөлийн гишүүнээр томилно.	3 дугаар зүйл. Олон нийтийн радио, телевизийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1 дэх заалтыг хассугай.	
2005 оны 2 дугаар сарын 17-ны өдөр	<b>МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ</b>	<b>МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА</b> <b>Н.ЭНХБАЯР</b>
<b>ОЛОН НИЙТИЙН РАДИО, ТЕЛЕВИЗИЙН ТУХАЙ ХУУЛИЙГ ДАГАЖ МӨРДӨХ ЖУРМЫН ТУХАЙ</b>	Улаанбаатар хот	
1 дүгээр зүйл. Олон нийтийн радио, телевизийн тухай хуулийн 13.2-т заасан арилжааны зар сурталчилгаа нэвтрүүлэхийг хориглосон	заалтыг 2006 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.	
2005 оны 1 дүгээр сарын 27-ны өдөр	<b>МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ</b>	<b>МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА</b> <b>Н.ЭНХБАЯР</b>
<b>Олон нийтийн радио, телевизийн тухай хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай</b>	Дугаар 09	Улаанбаатар хот
Олон нийтийн радио, телевизийн тухай, Төрийн өмчөөс олон нийтийн өмчид эд хөрөнгө шилжүүлэх тухай хууль батлагдсантай холбогдуулан Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:	2. Монгол Улсын хуулиар үйл ажиллагааны эрх зүйн үндэс нь тодорхойлогдсон төрийн бус байгууллагууд хоорондоо зөвшилцөх замаар Үндэсний зөвлөлийн 9 гишүүнийг сонгох талаар зөвлөмж гаргах, Үндэсний зөвлөлийн анхны хуралдааны бэлтгэлийг хангах, хуралдааныг зохион байгуулахыг Төрийн байгуулалтын болон Мэдээлэл, харилцаа холбоо, технологийн хөгжлийн байнгын хороонд тус тус даалгасугай.	
1. Олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлийн анхны хуралдааны дэгийг хавсралтаар баталсугай.		

3. Шинээр байгуулагдах олон нийтийн радио, телевиз үйл ажиллагаагаа хэвийн явуулахад нь шаардагдах, Төрийн өмчөөс олон нийтийн өмчид эд хөрөнгө шилжүүлэх тухай хуульд заасан эд хөрөнгийг олон нийтийн радио, телевизийн өмчлөлд шилжүүлэх ажлыг зохион байгуулахыг Засгийн газар /Ц.Элбэгдорж/-т даалгасугай.

4. Орон нутгийн өмчит радио, телевизийн өмч хөрөнгийг Олон нийтийн радио, телевизийн

тухай хуульд заасан зарчмын дагуу хувьчлахгүйгээр, тухайн орон нутагт байгуулагдах олон нийтийн радио, телевизэд шилжүүлэх замаар өөрчлөн байгуулах арга хэмжээ авахыг аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд зөвлөсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН ИХ  
ХУРЛЫН ДЭД  
ДАРГА**

**Д.ЛҮНДЭЭЖАНЦАН**

*Улсын Их Хурлын 2005 оны  
09 дугаар тогтоолын хавсралт*

## ОЛОН НИЙТИЙН РАДИО, ТЕЛЕВИЗИЙН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН АНХНЫ ХУРАЛДААНЫ ДЭГ

Нэг. Олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлийн анхны хуралдааныг Үндэсний зөвлөлийн даргыг сонгох хуртэл тус зөвлөлийн гишүүнээр сонгогдсон гишүүдээс насаар хамгийн ахмад нь, хэрэв тухайн гишүүн Үндэсний зөвлөлийн даргад нэр дэвшсэн бол насаар ахмад дараагийн гишүүн удирдан явуулна.

Хоёр. Үндэсний зөвлөлийн анхны хуралдааныг Үндэсний зөвлөлийн нийт гишүүдийн дөрөвний гурваас доошгүй нь хүрэлцэн ирснээр хүчинтэйд тооцож, хуралдаанд оролцсон

гишүүдийн олонхийн саналаар асуудлыг шийдвэрлэнэ. Харин Үндэсний зөвлөлийн даргыг сонгох асуудлыг Олон нийтийн радио, телевизийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу Үндэсний зөвлөлийн нийт гишүүдийн олонхийн саналаар шийдвэрлэнэ.

Гурав. Үндэсний зөвлөлийн анхны хуралдаанаар Олон нийтийн радио, телевизийн тухай хуулийн 22 дугаар зүйлд заасан асуудлуудыг хэлэлцэн шийдвэрлэнэ.

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2005 оны 2 дугаар  
сарын 17-ны өдөр

Дугаар 16

Улаанбаатар  
хот

### Ерөнхийлөгчийн хоригийн тухай

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн 14.3-ыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Ерөнхийлөгчөөс Олон нийтийн радио, телевизийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 13, 21 дүгээр зүйлд тавьсан хоригийг хүлээн зөвшөөрсүгэй.

2. Монгол Улсын Ерөнхийлөгчөөс Олон нийтийн радио, телевизийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалтад тавьсан хоригийг хүлээн зөвшөөрөх боломжгүй гэж үзсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**Н.ЭНХБАЯР**

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2005 оны 2 дугаар  
сарын 17-ны өдөр

Дугаар 17

Улаанбаатар  
хот

### Тогтоолд өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн 14.3-ыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Олон нийтийн радио, телевизийн тухай хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай Монгол Улсын Их Хурлын 2005 оны 1 дүгээр сарын 27-ны өдрийн 9 дүгээр тогтоолын 2 дахь хэсгийн "Монгол Улсын хуулиар үйл ажиллагааны эрх зүйн үндэс нь тодорхойлогдсон

төрийн бус байгууллагууд хоорондоо зөвшилцөх замаар Үндэсний зөвлөлийн 9 гишүүнийг сонгох талаар зөвлөмж гаргах" гэснийг хассугай.

2. Энэ тогтоолыг Олон нийтийн радио, телевизийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН ИХ  
ХУРЛЫН ДАРГА**

**Н.ЭНХБАЯР**

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2005 оны 2 дугаар сарын 17-ны өдөр

Дугаар 18

Улаанбаатар хот

### Ерөнхийлөгчийн хоригийн тухай

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн 14.3-ыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

бүхэлд нь Монгол Улсын Ерөнхийлөгчөөс тавьсан хоригийг хүлээн зөвшөөрөх боломжгүй гэж үзсүгэй.

Монгол Улсын Их Хурал 2005 оны 1 дүгээр сарын 28-ны өдөр баталсан Төрийн өмчөөс олон нийтийн өмчид эд хөрөнгө шилжүүлэх тухай хуульд

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА**

**Н. ЭНХБАЯР**

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2005 оны 2 дугаар сарын 18-ны өдөр

Дугаар 20

Улаанбаатар хот

### Засгийн газрын зарим гишүүнийг огцруулах тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 6 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1 дэх заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

хяналтын асуудал эрхэлсэн сайдын үүрэгт ажлаас тус тус огцруулсугай.

2. Энэ тогтоолыг 2005 оны 2 дугаар сарын 18-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

1. Бадарчийн Эрдэнэбатыг Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Батлан хамгаалахын сайдын, Ичинхорлоогийн Эрдэнэбаатарыг Монгол Улсын Засгийн газрын гишүүн, мэргэжлийн

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДЭД ДАРГА**

**Д.ЛҮНДЭЭЖАНЦАН**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2005 оны 1 дүгээр сарын 19-ний өдөр

Дугаар 04

Улаанбаатар хот

### Бавуугийн Цэрэндоржид Монгол Улсын ардын багш цол хүртээх тухай

Хүүхэд, залуучуудын байгууллагад олон жил санаачилга, үр бүтээлтэй ажиллаж хүүхдийн урлан бүтээх төвийг үндэслэн байгуулж, шинэ технологи, оновчтой санал гарган сургалт үйлдвэрлэлд нэвтрүүлэх замаар бүтээлч үйл ажиллагааг өрнүүлэн өсвөр үеийнхний авъяас чадварыг дэмжин хөгжүүлэх, тэдэнд гоо зүйн мэдрэмж, хөдөлмөрийн хүмүүжил олгоход оруулж

байгаа дорвитой хувь нэмрийг нь үнэлж хүүхдийн урлан бүтээх төвийн ерөнхий захирал Бавуугийн Цэрэндоржид Монгол Улсын ардын багш цол хүртээсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ**

**Н. БАГАБАНДИ**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2005 оны 1 дүгээр сарын 19-ний өдөр

Дугаар 05

Улаанбаатар хот

### Чойжилжавын Гунгаасүхэд Монгол Улсын ардын зураач цол хүртээх тухай

Мэргэжлийн урлагийн байгууллагад олон жил үр бүтээлтэй ажиллаж, дэлхийн сонгодог, үндэсний дуурь бүжгийн болон драмын жүжиг, өргөн дэлгэцийн киноны тайз, хувцас, чимэглэлийг мэргэжлийн бндөр түвшинд туурвиж, мснгслэн орчин цагийн тайзны дүрслэх урлагийг хөгжүүлэх үйлст оруулж байгаа дорвитой хувь нэмрийг нь

үнэлж Улсын дуурь, бүжгийн эрдмийн театрын зураач Чойжилжавын Гунгаасүхэд Монгол Улсын ардын зураач цол хүртээсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ**

**Н. БАГАБАНДИ**



## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2005 оны 1 дүгээр сарын 19-ний өдөр

Дугаар 06

Улаанбаатар хот

### Түвдийн Доржид Монгол Улсын шинжлэх ухааны гавъяат зүтгэлтэн цол хүртээх тухай

Их, дээд сургуульд олон жил багш, тэнхмийн эрхлэгч, захирлаар санаачилга, үр бүтээлтэй ажиллаж манай орны хөгжил, хэтийн төлөв, зах зээлийн шинэчлэлийн талаар дорвитой бүтээлүүд туурвиж, эдийн засгийн шинжлэх ухааныг хөгжүүлэх, дээд боловсролтой мэргэжилтэн бэлтгэхэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж МУИС-ийн Эдийн засгийн сургуулийн

тэргүүлэх профессор Түвдийн Доржид Монгол Улсын шинжлэх ухааны гавъяат зүтгэлтэн цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н. БАГАБАНДИ

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2005 оны 1 дүгээр сарын 19-ний өдөр

Дугаар 07

Улаанбаатар хот

### Дэмбэрэлийн Булгад Монгол Улсын гавъяат багш цол хүртээх тухай

Ерөнхий боловсролын сургуульд олон жил үр бүтээлтэй багшилж, заах аргын ур чадвар, сургалтын чанарыг дээшлүүлж, өсвөр үеийнхнийг сурган хүмүүжүүлэх үйлст оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж Төв аймгийн Зуунмод сумын "Хүмүүн цогцолбор" сургуулийн бага ангийн багш

Дэмбэрэлийн Булгад Монгол Улсын гавъяат багш цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н. БАГАБАНДИ

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2005 оны 1 дүгээр сарын 19-ний өдөр

Дугаар 08

Улаанбаатар хот

### Дамдинсүрэнгийн Нацагдоржид Монгол Улсын хүний гавъяат эмч цол хүртээх тухай

Монголын уламжлалт анагаах ухааныг эмчилгээ, сургалт, судалгаа, шинжилгээ, эм үйлдвэрлэлийн чиглэлээр сэргээн хөгжүүлж, хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагыг үүсгэн төлөвшүүлэх, олон хүнийг эмчлэн эдгэрүүлэхэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж "Манба дацан"-ийн хамба лам, зөвлөх оточ

Дамдинсүрэнгийн Нацагдоржид Монгол Улсын хүний гавъяат эмч цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н. БАГАБАНДИ

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2005 оны 1 дүгээр сарын 19-ний өдөр

Дугаар 09

Улаанбаатар хот

### Цэрэндоржийн Балдоржид Монгол Улсын соёлын гавъяат зүтгэлтэн цол хүртээх тухай

Хэвлэл мэдээллийн байгууллагад олон жил санаачилга, үр бүтээлтэй ажиллаж хэвлэлийн нийтлэлийн бодлого, чанарыг сайжруулан, төрийн болон чөлөөт хэвлэл, мэдээллийн байгууллагыг сүлжээг үүсгэн төлөвшүүлж, шинэ техник технологи, удирдлагын шинэ арга барил нэвтрүүлэн, тайз, дэлгэцийн олон сайн бүтээл туурвиж, нийгмийн шинэчлэл өөрчлөлтөд дуудсан чамбай нийтлэлүүд бичиж хүн ардынхаа оюуны сан

хөмрөгийг баяжуулахад оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж "Монгол ньюс" ХХК-ийн ерөнхий захирал, зохиолч, сэтгүүлч Цэрэндоржийн Балдоржид Монгол Улсын соёлын гавъяат зүтгэлтэн цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н. БАГАБАНДИ

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2005 оны 2 дугаар  
сарын 4-ний өдөр

Дугаар 11

Улаанбаатар хот

### Аюурзанын Долгорт Монгол Улсын ардын жүжигчин цол хүртээх тухай

Мэргэжлийн урлагийн байгууллагад олон жил үр бүтээлтэй ажиллан үндэсний болон дэлхийн сонгодог дуурийн гол дүрүүдийг мэргэжлийн өндөр түвшинд бүтээж, зохиолын болон ардын дууг чадварлаг дуулж, Монголын орчин цагийн дууны урлагийг хөгжүүлэхэд оруулж байгаа дорвитой хувь нэмрийг нь үнэлж Улсын дуурь, бүжгийн эрдмийн

театрын гоцлол дуучин Аюурзанын Долгорт Монгол Улсын ардын жүжигчин цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н. БАГАБАНДИ

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2005 оны 2 дугаар  
сарын 4-ний өдөр

Дугаар 12

Улаанбаатар хот

### Шарын Чимэдцээд Монгол Улсын ардын жүжигчин цол хүртээх тухай

Мэргэжлийн урлагийн байгууллагад олон жил үр бүтээлтэй ажиллаж үндэсний урлагийн сонгодог төрөл-уртын дуу болон ардын, зохиолын дуунуудыг чадварлаг дуулж, Монгол ардын уртын дууг сурталчлах, түүнийг залгамж хойч үеийнхэнд өвлүүлэхэд оруулж байгаа дорвитой хувь нэмрийг нь үнэлж Улсын филармоний "Морин хуур" чуулгын

гоцлол дуучин Шарын Чимэдцээд Монгол Улсын ардын жүжигчин цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н. БАГАБАНДИ

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2005 оны 2 дугаар  
сарын 4-ний өдөр

Дугаар 13

Улаанбаатар хот

### Зарим хүмүүст Монгол Улсын гавъяат малчин цол хүртээх тухай

Мал сүргээ олон жил тогтвортой өсгөн үржүүлж, үүлдэр угсааг нь сайжруулан, ашиг шимийг сайн ашиглаж, иргэдийг малжуулахад идэвх санаачилга гарган, мал аж ахуйн үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж дор дурдсан хүмүүст Монгол Улсын гавъяат малчин цол хүртээсүгэй.

2. Даарийбумын Цэрэндорж- Хэнтий аймгийн Өмнөдэлгэр сумын Чандан багийн малчин

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н. БАГАБАНДИ

1. Дамбадаржаагийн Гомбодаш- Төв аймгийн Эрдэнэсант сумын 4 дүгээр багийн малчин

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргав.  
"Төрийн Мэдээлэл" эмхтгэлийн зөвлөл  
Улаанбаатар- 12,  
Төрийн ордон  
☎ 329612 Индекс 14003

Монгол Улсын Их Хурлын Тамгын газрын  
Хэвлэх хэсэгт хэвлэв.  
☎ 329487  
Хэвлэлийн хуудас 2